



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 19 өдөр

Дугаар A/88

Улаанбаатар хот

“Хариуцлагатай газрын харилцаа”
аян зохион байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1 дэх заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5³ дугаар зүйлийн 5³.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Салбарын хууль тогтоомжийг иргэд олон нийтэд сурталчилах, газрын зөрчил маргаанаас урьдчилан сэргийлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулах, төрийн хяналт шалгалтыг иргэдэд ойлгомжтой болгох, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанаас газар түүний хөрсөнд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хариуцлагатай газрын харилцаа” аяныг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 30-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Аяныг зохион байгуулан хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Аяныг үр дүнтэй зохион байгуулах арга хэмжээ авахыг нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, газрын даамалд, уг арга хэмжээг холбогдох газруудтай хамтран шуурхай зохион байгуулж Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд нэгтгэсэн тайланг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэг (Д.Түвшинбат)-т тус тус даалгасугай.

4. Аяныг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг холбогдох зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (Г.Халиунбигэрт)-т зөвшөөсүгэй.

ДАРГА

А.ЭНХМАНЛАЙ



Газар зохион байгуулалт, геодези,
зураг зүйн өрөнхий газрын даргын
2024 оны 4/28 тушаалын
нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч

Салбарын хяналт шалгалтын хэлтсийн дарга
Д.Түвшинбат

Нарийн бичгийн дарга

Газар, геодези, зураг зүйн хяналтын улсын ахлах
байцаагч Д.Бямбадулам

Гишүүд

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн өрөнхий
газрын холбогдох хэлтсийн албан хаагчид


Салбарын хяналт шалгалтын хэлтсийн Газар, геодези,
зураг зүйн хяналтын улсын болон ахлах байцаагч нар

Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны
дарга нар

21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын дарга

21 аймгийн Газар, геодези, зураг зүйн хяналтын улсын
болон ахлах байцаагчид нар

Сумдын газрын даамлууд



Газар зохион байгуулалт, геодези,
зураг зүйн ерөнхий газрын даргын
2024 оны 7/8 тушаалын
хоёрдугаар хавсралт

“ХАРИУЦЛАГАТАЙ ГАЗРЫН ХАРИЛЦАА” АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Аяны үндэслэл, зорилго:

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө, Монгол Улсад газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойг тохиолдуулан хэрэгжүүлэх бүтээлч ажлын төлөвлөгөөний дагуу Салбарын хууль тогтоомжийг иргэд олон нийтэд сурталчилах, газрын зөрчил маргаанаас урьдчилан сэргийлэх, төрийн хяналт шалгалтыг иргэдэд ойлгомжтой болгох, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанаас газар түүний хөрсөнд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахад аяны зорилго оршино.

Хоёр. Аяныг зохион байгуулах хугацаа:

“Хариуцлагатай газрын харилцаа” аяныг 2024 оны 04 дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн 05 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулна.

Гурав. Аяны хамрах хүрээ, хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1. Улсын хэмжээнд нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумын газрын даамал, Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд, Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээд, газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллага хамрагдана.

3.2. Ажлын хэсэг нь дараах ажлуудыг зохион байгуулж, хэрэгжүүлнэ. Үүнд:

3.2.1. “Хариуцлагатай газрын харилцаа” аяныг зохион байгуулах, тайлан мэдээ гаргаж танилцуулах;

3.2.2. Газар, геодези, зураг зүйн чиглэлээр зөвлөмж, постер, бэлтгэх, гарын авлага боловсруулах;

3.2.3. Газрын харилцаа, геодези, зураг зүйн чиглэлээр иргэн, аж ахуйн нэгж байгуулагуудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх;

3.2.5. Сууц өмчлөгчдийн дээд зөвлөлтэй хамтран сууц өмчлөгчдийн дарга нарт сургалт зохион байгуулах, сууц өмчлөгчдийн холбоонд орчны газрыг баталгаажуулах талаар зөвлөмж, мэдээлэл хүргүүлэх;

3.2.6. Орон сууцны орчны зам талбайд байрлуулсан хаалтыг чөлөөлөх ажлыг аймаг, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албатай хамтран судалгаа гаргаж, хяналт шалгалт хийж зөрчлийг арилгуулах;

3.2.7. Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулах зорилгоор Явган хүний зам, нийтийн эзэмшлийн зам талбай, орц гарц хаасан хашаа хаалт, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй газар ашигласан, газрын талбайн хэмжээг өөрчлөн илүү талбай ашигласан иргэн, хуулийн этгээдийн газар ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах, холбогдох арга хэмжээг нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай хамтран зохион байгуулах;

3.2.8. Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн бүрэн бүтэн байдлыг хангуулах сургалт зохион байгуулах, олон нийтэд таниулан суртачлах

3.2.9. “Барилга байгууламжид хийх геодезийн ажил”-ын үзүүлэх сургалт зохион байгуулах


Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу албан хаагчдын сахилга, хариуцлага, мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор 10 удаагийн цахим болон танхимиын сургалтыг зохион байгуулна.

Тав.Аяны дүнг танилцуулга

5.1. Аяны үйл ажиллагааны явц байдал, тайлан, мэдээг сар тутам авч нэгтгэн дүгнэх, удирдлагад танилцуулах;

5.2. “Хариуцлагатай газрын харилцаа” аяны нэгдсэн тайлан, танилцуулга бэлтгэх, үр дүнгийн талаар санал, дүгнэлт боловсруулах;

5.3. Аяны дүн мэдээг нэгтгэн гаргаж, нэгдсэн танилцуулга боловсруулж Газрын даргад танилцуулах.



Газар зохион байгуулалт, геодези,
зураг зүйн ерөнхий газрын даргын
2024 оны 07.30 тушаалын
гуравдугаар хавсралт

“ХАРИУЦЛАГАТАЙ ГАЗРЫН ХАРИЛЦАА” АЯНЫ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийх ажил	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
Нэг. Аяны бэлтгэл ажлын хүрээнд хийх ажил				
1.1	Салбарын хууль тогтоомж, норм, дурэм, журам, стандартыг сурталчлах, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр мэдээлэл хүргэх ажлуудыг үе шаттай зохион байгуулах,	Аяны нэгдсэн цахим анонсыг бэлтгэх	2024.3.25	А.Даваажав
		Аяны хүрээ, нээлтийн бэлтгэл ажлыг хангуулж, нээлтийн үйл ажиллагаа эхлүүлэх	2024.04.01	Д.Түвшинбат
		Газар, геодези, зураг зүйн хяналтын чиглэлээр илэрч буй зөрчил, Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааны талаар бэлдэх Веб хуудсанд подкаст бэлтгэж оруулах, брошур бэлтгэх	2024.03.25 2024.05.30	М.Бат-Очир (СХШХ) Бүх байцаагчид
		Газрын кадастрын мэдээллийн системийн чиглэлээр брошур бэлтгэх /egazar.gov.mn/	2024.04.01 2024.05.30	С.Энх-Эрдэнэ (КХ)
		Газар өмчлөлийн чиглэлээр брошур бэлтгэх Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системийн танилцуулга брошур бэлтгэх	2024.04.01 2024.05.30	С.Эрдэнэтуюя (ГЗБХ) Г.Пүрэвжаргал (ГЗБХ) Э.Бүжинлхам (ГЗБХ)
		Иргэд олон нийтэд шинэчлэн батлагдсан “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх	2024.04.01 2024.05.30	Г.Анхбаяр ГМХ-ийн албан хаагчид

		журам"-ыг мэдээлэх, таниулах ажлыг зохион байгуулах Веб хуудсанд подкаст бэлтгэж оруулах, брошур бэлтгэх		
		Тараах материалыг хэвлүүлэх	2024.03.25-2024.04.01	М.Бат-Очир (СХШХ)
1.2	"Хариуцлагатай газрын харилцаа" аяны нээлт орон даяар зохион байгуулах, аймаг орон нутагт чиглэл хүргүүлэх	Нээлтийг улс орон даяар зэрэг зохион байгуулах талаар цахим сургалт зохион байгуулах	2024.04.01	Д.Тувшинбат Д.Бямбадулам Ч.Энхчимэг
1.3	"Хариуцлагатай газрын харилцаа" сарын аяны талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулах	Аяны талаарх мэдээллийг 14 хоног бүр нэгтгэж байгууллагын цахим хуудсанд байршуулах	14 хоног бүр сар бүрийн 25-ны дотор	А.Даваажав, О.Бат-Очир нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
Хоёр. Урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх				
2.1	Аймгийн газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагчдад аян зохион байгуулах ажлын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх танхимиын болон цахим сургалт зохион байгуулах	Сургалт зохион байгуулж, дүнгийн танилцуулга нэгтгэх	2024.04.09	Б.Наранцэцэг Бүх байцаагчид
2.2	Сууц өмчлөгчдийн холбоонд орчны газрыг баталгаажуулах талаар зөвлөмж, мэдээлэл хүргүүлэх, СӨХ-ны дарга наарт сургалт зохион байгуулах,	Сургалт зохион байгуулах	2024.04.20	Д.Бямбадулам Бүх байцаагчид Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба

2.3	Баг, хорооны Засаг даргатай хамтран иргэн, хуулийн этгээдэд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн эрх, үүрэг, зөрчил түүнээс урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулах	Сургалт зохион байгуулах	Тухай бүр	Ч.Энхчимэг Х.Нямдулам Бүх байцаагчид Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
Гурав. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлын хүрээнд				
3.1	Орон сууцны орчны зам талбайд байрлуулсан хаалтыг чөлөөлөх ажлыг нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албатай хамтран судалгаа гаргаж, хяналт шалгалт хийж зөрчлийг арилгуулах	Удирдан зохион байгуулах	2024.04.01 2024.05.20	А.Даваажав
		Газар зохион байгуулалтын албатай хамтран судалгаа гаргаж /21 аймаг/	2024.04.01 2024.04.15	Х.Нямдулам Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
		Хяналт шалгалт хийж зөрчлийг арилгуулах.	2024.04.01 2024.05.20	Дүнгийн танилцуулга нэгтгэх А.Даваажав М.Бат-Очир Аймгийн газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч
3.2	Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулах зорилгоор	Удирдан зохион байгуулах	2024.04.01 2024.05.20	Т.Эрдэнэболов
		Явган хүний зам, нийтийн эзэмшлийн зам талбай, орц, гарц хаасан хашаа хаалтын судалгаа гаргах	2024.04.01 2024.04.15	Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Сууц өмчлөгчдийн холбоо

		Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй газар ашигласан судалгаа гаргах	2024.04.01 2024.04.15	Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
		Газрын талбайн хэмжээг өөрчлөн илүү талбай ашигласан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах	2024.04.01 2024.05.15	Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
3.3	Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг арчлан хамгаалах зорилгоор	Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн бүрэн бүтэн байдлыг хангуулах сургалт зохион байгуулах, олон нийтэд таниулан суртаачлах ажлыг зохион байгуулах	2024.04.15	Б.Наранцэцэг А.Даваажав Л.Золзаяа (ГЗЗХэлтэс) Д.Ундармаа (ГЗЗХэлтэс) Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
		Цэг, тэмдэгт байрлаж байгаа газарт барилга, байгууламж, газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээдийн судалгаа гаргах	2024.04.01	Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
3.4	Үзүүлэх сургалт зохион байгуулах	“Барилга байгууламжид хийх геодезийн ажил”-ын үзүүлэх сургалт зохион байгуулах	2024.05.10	Б.Наранцэцэг А.Даваажав М.Бат-Очир Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоо болон геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллагууд
Дөрөв. Албан хаагчдын сахилга хариуцлага, мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах				

4.1	Агаар, сансрын зургаар газар ашиглалтын зөрчлийг тогтоох нь	Нийт албан хаагчдад онлайн сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангах	2024.04.20	Т.Бадамцэрэн (ГЗЗХэлтэс)
4.2	Сумдад үүсгэсэн нэгж талбарын хувийн хэргийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын архивт хүлээлгэн өгөх	Сумдад үүссэн нэгж талбарын хувийн хэргийг ГХБХБГ-ын архивт хүлээн авах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах Ерөнхийлөгчийн өгсөн үүрэг чиглэлийн хүрээнд аймгуудад хийсэн хяналт шалгалтаар татааж авсан нэгж талбарын хувийн хэргийг аймгийн ГХБХБГ-ын архивт хүлээн авах	2024.04.20 2024.05.20 2024.04.01 2024.05.20	Л.Мандхай (САХ) Л.Мандхай (САХ)
4.3	Аймгийн газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагчдыг чадавхжуулах сургалт	Хяналт шалгалтад анхаарах зүйл, хяналт шалгалтын төлөвлөгөөний талаар цахим сургалт зохион байгуулах	2024.04.01 2024.05.20	Ч.Энхчимэг Д.Бямбадулам
4.4	Нийслэл, дүүргүүдийн газар зохион байгуулагч, бүртгэлийн мэргэжилтнүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг зохион байгуулах	Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанад хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, анхаарах асуудлын талаар сургалт зохион байгуулах	2024.04.01 2024.05.20	Д.Түвшинбат Улсын байцаагчид
4.5	Газар зохион байгуулалт хийх шинэчлсэн журам	Нийслэл, дүүргийн ГЗБА, 21 аймгийн ГХБХБГ-ын албан хаагчдад цахим сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангах.	2024.05.01- 2024.06.10	Г.Гэрэлтуяа (ГЗБХ)
4.6	Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системийн хэрэглээ	Газар зохион байгуулалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн байгууллагуудад онлайн сургалтыг зохион байгуулах:	2024.04.01- 2024.06.10	Г.Пүрэвжаргал (ГЗБХ) Э.Бүжинлхам (ГЗБХ)
4.7	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний ач холбогдол, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн өнөөгийн байдал	Их, дээд сургуулийн оюутнуудад	2024.04.01- 2024.06.01	Г.Гэрэлтуяа (ГЗБХ) Б.Тэргүүнцэцэг (ГЗБХ)
4.8	Газрын даамлын иргэдэд үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний чанар хүртээмж, ажлын ачаалал тооцох	Аймгийн ГХБХБГ-ын нэгж, албан хаагчдын ажлын ачаалал иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмж, чиг үүргүүдийг оновчтой хуваарилах	2024.04.01- 2024.04.30	Төрийн захиргаа, удирдлагын газар, Хуулийн хэлтэс

		зорилгоор 2 аймгийн ГХБХБГ болон 1 суманд ажлын зураг авалт хийх		
4.9	Аймгийн ГХБХБГ-ын албан хаагчдад сургалт зохион байгуулах	Төрийн албаны тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, шинээр батлагдсан Засгийн газрын тогтоол, Төрийн албаны зөвлөлийн тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр цахим сургалт зохион байгуулах	2024.04.01-2024.04.30	Төрийн захиргаа, удирдлагын газар, Хуулийн хэлтэс
4.10	Газрын кадастрын мэдээллийн системд хийсэн хяналт шалгалтын үр дүнд илэрсэн алдаа дутагдлыг арилгах, мэдээллийн үнэн зөв байдлыг хангах чиглэлээр сургалт зохион байгуулах, зөвлөмж, чиглэл хүргүүлэх	Газрын кадастрын мэдээллийн системд хийсэн хяналт шалгалтын үр дүнд илэрсэн алдаа дутагдлыг арилгах, мэдээллийн үнэн зөв байдлыг хангах чиглэлээр сургалт зохион байгуулах, зөвлөмж, чиглэл хүргүүлэх	2024.04.01 2024.05.10	С.Энх-Эрдэнэ (КХ)
Тав. "Хариуцлагатай газрын харилцаа" сарын аяныг тайлагнах, дүгнэх ажлын хүрээнд хийх ажил				
5.1	Аян зохион байгуулсан тайлан мэдээг ирүүлсэн хүснэгтийн дагуу нэгтгэх	Хүснэгтийн дагуу тайлан мэдээг орон нутгийн байцаагчдаас хүлээн авч нэгтгэх	Сар бүрийн 20-ны дотор	А.Даваажав Б.Наранцэцэг
5.2	Аяны хүрээнд зөвлөн туслах, хууль сурталчлах, мэдээлэл түгээх чиглэлээр хийсэн ажлыг нэгтгэх	Ажлын мэдээг 7 хоног тутам байцаагч нараас авч нэгтгэн хэлтсийн даргад танилцуулж, шийдвэрлүүлж байх	Сар бүрийн 20-ны дотор	М.Бат-Очир
5.3	Аяны үйл ажиллагааны явц байдал, тайлан, мэдээг сар тутам авч нэгтгэн дүгнэж, хэлтсийн даргыг мэдээллээр хангах	Тухай бүрд нь Хэлтсийн даргад танилцуулах	тухай бүр	Д.Бямбадулам Ч.Энхчимэг
5.4	"Хариуцлагатай газрын харилцаа" аяны нэгдсэн тайлан, танилцуулга бэлтгэх, санал, дүгнэлт боловсруулах	Аяны нэгдсэн танилцуулга бэлтгэх	2024.05.31	Д.Түвшинбат Д.Бямбадулам Ч.Энхчимэг Б.Наранцэцэг А.Даваажав
5.5	Аяны тайлан мэдээг нэгтгэн гаргаж, нэгдсэн танилцуулга боловсруулж газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулах	Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулах	2024.06.01	Д.Түвшинбат Д.Бямбадулам Ч.Энхчимэг Б.Наранцэцэг А.Даваажав